



Bank of Mongolia

**МОНГОЛ УЛСЫН ХӨГЖЛИЙН БАНКИНД  
МОНГОЛБАНКНААС ХЭРЭГЖҮҮЛСЭН  
ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ҮЙЛ  
АЖИЛЛАГААНЫ ТУХАЙ**

**UIH.MN**  
СУДАЛГААНЫ САН



# Агуулга

- **Ерөнхий мэдээлэл**
- **Монголбанкнаас МУХБ-д 2018 онд хийсэн шалгалтын тухай**
- **Монголбанкнаас МУХБ-д 2021 онд хийсэн хэсэгчилсэн шалгалтын тухай**
- **Цаашид авах арга хэмжээ**

ᠮᠣᠩᠭᠣᠯᠪᠠᠨᠭᠠᠨᠠᠨᠠᠭᠤ

UIH.MN  
СУДАЛГААНЫ САН



## Ерөнхий мэдээлэл

- ❑ Монгол Улсын Хөгжлийн банкны тухай хууль 2017 оны 2 дугаар сарын 10-нд шинэчлэн батлагдсан.
- ❑ Монголбанкны Ерөнхийлөгчийн 2017 оны 11 дүгээр сарын 03-ны өдрийн А-286 дугаар тушаалаар тус банкинд төрийн өмчийн төрөлжсөн банкны гэрчилгээ олгосон. Тус банк МУХБТХ-ийн 8.1-т заасан төсөл, хөтөлбөр санхүүжүүлэх, төлбөр тооцоо хийх, баталгаа, батлан даалт гаргах, үнэт цаас гаргах, санхүүгийн хэрэгсэл худалдах, худалдан авах, хадгалуулах, зээл авах, гадаад валют худалдах, худалдан авах, хадгалуулах, компанийн хувьцаа эзэмших, хөрөнгө оруулалтын санд хөрөнгө оруулалт хийх, төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх зорилгоор зөвлөх үйлчилгээ үзүүлэх, экспорт, импортын санхүүжилт хийх, төлбөрийн чадварыг сайжруулах, ашигт ажиллагааг нэмэгдүүлэх зорилгоор богино, дунд хугацаатай санхүүгийн эх үүсвэр татан төвлөрүүлэх үйл ажиллагааг эрхэлж байна.





## Ерөнхий мэдээлэл

- Энэхүү хуулийн 25.1-д “Хөгжлийн банкны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг тогтоох, түүнд хяналт тавих журам, активыг ангилах, активын эрсдэлийн сан байгуулах, зарцуулах журмыг санхүү төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний саналыг харгалзан Монголбанк батална.” гэсний дагуу Монголбанкны Ерөнхийлөгчийн 2017 оны 10 дугаар сарын 03-ны өдрийн А-251 дүгээр тушаалаар баталсан “Хөгжлийн банкны активыг ангилах, активийн эрсдэлийн сан байгуулж, зарцуулах журам”, 2017 оны 5 дугаар сарын 30-ны өдрийн А-164 дүгээр тушаалаар баталсан “Хөгжлийн банкны үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлт тогтоох, түүнд хяналт тавих журам” батлагдсан.
- Дээрхи журмын хүрээнд Монголбанкнаас дангаараа Хөгжлийн банкинд 2018, 2021 онуудад Монголбанк газар дээрх шалгалт хийсэн байна.

ᠮᠣᠩᠭᠣᠯᠪᠠᠨᠭ

OIH.MN  
СУДАЛГААНЫ САН



# Монголбанкнаас МУХБ-д 2018 онд хийсэн шалгалтын тухай

Нийгэм, эдийн засгийн нөхцөл байдал /2018 оны 7-р сарын байдлаар/

Үзүүлэлтүүд	7/20/2018
Инфляци	7.7 хувь /жилийн/
ДНБ /оны үнээр, их наяд төгрөгөөр/	15.4
Гадаад валютын албан нөөц /тэрбум ам.доллар/	2,952.9
Ам.долларын төгрөгтэй харьцуулсан албан ханш /төгрөгөөр/	2,461.7
Монголбанкны бодлогын хүү	10.0%
Банкны системийн нийт актив /их наяд төгрөг/	27.5
Улсын төсөв	
Орлого /их наяд төгрөг/	8.0
Зарлага /их наяд төгрөг/	9.9
Тэнцэл /их наяд төгрөг/	-1.9
Төлбөрийн тэнцэл /сая ам.доллар/	63.3

ᠮᠣᠩᠭᠣᠯᠪᠠᠨᠭᠠᠨᠠᠭᠤᠨ

UHL.MN  
СУДАЛГААНЫ САН



# Монголбанкнаас МУХБ-д 2018 онд хийсэн шалгалтын тухай

## МУХБ-ны 2018.07.20-ны байдлаарх тэнцэл

Шалгах өдрөөр /2018.07.20/

ХӨРӨНГӨ /тэрбум төг./	Банкны тэнцэл	Тохируулга	Тох.Дараах	%
Мөнгөн хөрөнгө	767.5		767.5	21.9%
Хөрөнгө оруулалт	209.0		209.0	6.0%
Зээл (цэвэр)	2,224.2		2,143.9	61.2%
/ЗТУБАХСАН/	-237.8	-80.3	-318.1	
Нийт Зээл	2,462.0		2,462.0	
Бусад хөрөнгө	353.9		353.9	10.1%
Үндсэн хөрөнгө (цэвэр)	27.4		27.4	0.8%
<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>3,581.9</b>		<b>3,501.6</b>	<b>100.0%</b>
<b>ӨР ТӨЛБӨР /тэрбум төг./</b>				
Харилцах, Хадгаламж	11.8		11.8	0.3%
Банк, СБ-с татсан эх үүсвэр	1,611.0		1,611.0	46.0%
Бусад эх үүсвэр	893.8		893.8	25.5%
Бусад өр төлбөр	-33.9		-33.9	-1.0%
<b>ӨР ТӨЛБӨРИЙН НИЙТ ДҮН</b>	<b>2,482.6</b>		<b>2,482.6</b>	<b>70.9%</b>
Эзэмшигчдийн өмч	1,099.3		1,019.0	29.1%
Тухайн жилийн ашиг, алдагдал	27.3	-80.3	-53.0	
Өмнөх үеийн ашиг алдагдал	-157.7		-157.7	
<b>ӨР ТӨЛБӨР БА ЭЗЭМШИГЧДИЙН ӨМЧ</b>	<b>3,581.9</b>		<b>3,501.6</b>	<b>100.0%</b>

ᠮᠣᠩᠭᠣᠯᠪᠠᠨᠭᠠᠨᠠᠭᠤᠨ 2᠐18 онд хийсэн шалгалт

Монголбанкнаас 2018 онд хийсэн шалгалт




# Монголбанкнаас МУХБ-д 2018 онд хийсэн шалгалтын тухай

Монголбанкнаас тогтоосон зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг хангасан байдал

Д/д	Зохистой харьцааны үзүүлэлт	2018.07.20-ны байдлаар		
		Банкнаас ирүүлсэн	Хянан шалгагчийн тооцсоноор	Зохистой харьцааг хангасан эсэх
1	Өөрийн хөрөнгө, эрсдэлээр жигнэсэн активын харьцаа ( $\geq 9.0\%$ )	34.00%	32.22%	Тийм
2	Төлбөр түргэн гүйцэтгэх чадварын харьцаа ( $\geq 100\%$ )	161.0%	161.0%	Тийм
4	Зээл, баталгаа, зээлтэй адилтгах актив хөрөнгийн нийт дүн нь өөрийн хөрөнгийн хэмжээг 30 дахин нэмэгдүүлсэн хэмжээнээс хэтрэхгүй байх	12.4 дахин их	11.7 дахин их	Тийм
6	Нийт том зээлдэгчид олгосон зээл, зээлтэй адилтган тооцох хөрөнгө, баталгаа, батлан даалтын нийлбэр дүн нь нийт зээл, зээлтэй адилтгах актив, баталгаа, батлан даалтын нийлбэр дүнгийн 80%-иас хэтрэхгүй байх	9.2%	9.2%	Тийм

УИХ-аас 2018 онд хийсэн шалгалт

Монголбанкнаас 2018 онд хийсэн шалгалт





# Монголбанкнаас МУХБ-д 2018 онд хийсэн шалгалтын тухай

## □ Монголбанкнаас шалгалтаар илэрсэн зөрчилд тогтоосон акт, мэдэгдэл

1. Зээл олголт, түүнд тавих хяналтанд аудитлагдсан санхүүгийн тайланг зээлдэгчээс авдаггүй нь “Хөгжлийн банкны активыг ангилах, активын эрсдэлийн сан байгуулж, зарцуулах журам”-ын 2.1.6 дахь заалтыг зөрчсөн, тус банкны зээлийн бодлогын 4.2.2-т “Зээлдэгч нь шүүхийн шийдвэрийн өргүй байх” гэсэн боловч шүүхийн лавлагаагаар 267.3 сая төгрөгийн өртэй зээлдэгчид зээл олгосон байв.
2. Зээл олголт, түүнд тавих хяналтанд аудитлагдсан санхүүгийн тайланг зээлдэгчээс авдаггүй нь “Хөгжлийн банкны активыг ангилах, активын эрсдэлийн сан байгуулж, зарцуулах журам”-ын 2.1.6 дахь заалтыг зөрчсөн, тус банкны зээлийн бодлогын 4.2.2-т “Зээлдэгч нь шүүхийн шийдвэрийн өргүй байх” гэсэн боловч шүүхийн лавлагаагаар 267.3 сая төгрөгийн өртэй зээлдэгчид зээл олгосон, барьцаа хөрөнгийг мэргэшсэн биш эдийн засагч үнэлж байгаа, зээлийн зарцуулалт болон төслийн гүйцэтгэлийн тайланг цаг хугацаанд нь гаргуулан авч, хяналт тавьж ажилладаггүй, зээлийг бүтээн байгуулалтын үе шаттай уялдуулан хэсэгчлэн олгоогүй, зээлийн эргэн төлөгдөх эх үүсвэр хангалтгүй, зээлийн бүтцийг өөрчилж, гэрээний хугацааг сунгадаг, зээлийн

ᠮᠣᠩᠭᠣᠯᠪᠠᠨᠭᠠᠨᠠᠭᠤᠰᠤ





# Монголбанкнаас МУХБ-д 2018 онд хийсэн шалгалтын тухай

- ❑ Монголбанкнаас шалгалтаар илэрсэн зөрчилд тогтоосон акт, мэдэгдэл барьцаанд зөвхөн дансны орлого, компанийн хувьцаа, тусгай зөвшөөрөл, ирээдүйд бий болох хөрөнгө барьцаалж байгаа, зээлийн бодлого, журамд заасан шаардлагууд, тогтоол шийдвэрт дурдсан нөхцөлүүд хангагдаагүй байхад зээлийг олгосон байв.
- 3. Зээлийн тусгайлсан болон бүлгийн эрсдэлийн сан байгуулах дотоод аргачлалыг батлаагүй, журмаар зохицуулагдаагүй байв.
- 4. МУХБТХ-д заасан банкны ТУЗ, Гүйцэтгэх удирдлагад тавигдсан зарим шаардлагыг биелүүлж ажиллаагүй байна.
- 5. Арилжааны банкуудаар дамжуулан олгож буй зээлийн барьцаа хөрөнгөд банкуудаас батлан даагчгүй вексель авсан хэвээр, зээлийн гэрээнд зээлдэгч банк төлбөрийн чадваргүй болсон тохиолдолд векселийг мөнгөжүүлэх асуудал тодорхой бус байв.

ᠮᠣᠩᠭᠣᠯᠪᠠᠨᠭᠠᠨᠠᠭᠤᠨ

UIN.MN  
СУДАЛГААНЫ САН



# Монголбанкнаас МУХБ-д 2018 онд хийсэн шалгалтын тухай

- Монголбанкнаас шалгалтаар илэрсэн зөрчилд тогтоосон акт, мэдэгдэл
  - 6. МУХБТХ-д заасан банкны ТУЗ, Гүйцэтгэх удирдлагад тавигдсан зарим шаардлагыг биелүүлж ажиллаагүй байна.
  - 7. Тус банкинд гадаад валют худалдах, худалдан авах, хадгалуулах энгийн зөвшөөрлийг зөвхөн ханшийн эрсдэлээс хамгаалах зорилгоор Төв банкттай гадаад валютын своп, спот хэлцэл хийх нөхцөлөөр, үнэт цаас гаргах, худалдах, худалдан авах нэмэлт зөвшөөрлийг Төв банкны үнэт цаасны хоёрдогч захын арилжаанд оролцох, Засгийн газрын богино хугацаат үнэт цаас худалдах, худалдан авах нөхцөлтэйгээр олгосон хэдий ч эрсдэлээс хамгаалах арга хэмжээ авч чадаагүй.
  - 8. Монголбанкны Ерөнхийлөгч, Сангийн сайдын хамтарсан 2017 оны А-294/340 дугаартай тушаалаар батлагдсан “Нягтлан бодох бүртгэлийн багц материал”, “Хөгжлийн банкны актив ангилах, активийн эрсдэлийн сан байгуулах журам”, “Монгол Улсын Хөгжлийн банкны үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлт тогтоох, түүнд хяналт тавих журам” зөрчсөн үндэслэлээр 2 акт тогтоосон байна.

ᠮᠣᠩᠭᠣᠯᠪᠠᠨᠭᠠᠨᠠᠭᠤᠯᠠᠭᠤᠨ

УИАН  
СУДАЛГААНЫ САН



# Монголбанкнаас МУХБ-д 2018 онд хийсэн шалгалтын тухай

## □ Монголбанкны Ерөнхийлөгчийн тушаалаар өгсөн үүрэг, даалгавар



### МОНГОЛБАНКНЫ ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ТУШААЛ

2018 оны 11 сарын 17 өдөр

Дугаар А-210

Улаанбаатар хот

Монгол Улсын Хөгжлийн банкнд  
хийсэн шалгалтын дүнгийн тухай

Монгол Улсын Хөгжлийн банкнд хийсэн ээлжит, иж бүрэн шалгалтаар Монголбанкнаас тогтоосон үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүдийг банк ханган ажиллаж байгаа боловч эрсдэлийн санг бүрэн байгуулаагүй, зээлийн зарцуулалт болон төслийн гүйцэтгэлтэй холбоотой хяналт сул, банкны зохистой засаглалыг сайжруулах шаардлагатай зэргийг тэмдэглэж, Төв банк (Монголбанк)-ны тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг, 27 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг, 28 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 2 дахь заалт, Монгол Улсын Хөгжлийн банкны тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.2 дахь хэсэг, Банкны тухай хуулийн 2 дүгээр зүйл, 43 дугаар зүйлийн 43.2 дахь хэсэг, Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, төлбөр тооцоо, зээлийн үйл ажиллагааны тухай хуулийн 27.1 дэх хэсэг, "Хөгжлийн банкны активыг ангилах, активын эрсдэлийн сан байгуулах, зарцуулах журам"-ын 1.3, 1.6 дахь заалт, "Монгол Улсын Хөгжлийн банкны үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлт тогтоох, түүнд хяналт тавих журам"-ын 2.6.2, 5.1 дэх заалт, Монголбанкны Банкны хяналт шалгалтын хорооны 2018 оны 11 дүгээр сарын 23-ны өдрийн хуралдааны тэмдэглэлийг үндэслэн ТУШААХ нь:

НЭГ. Шалгалтын акт, материалыг 1 дүгээр, зөрчлийн жагсаалтыг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

ХОЁР. Монгол Улсын Хөгжлийн банкны ТУЗ-ийн дарга (М.Баярмагнай), Гүйцэтгэх захирал (Б.Батбаяр) нарт үүрэг болгох нь:

1. Нийт зээлийн хэмжээг 2.6 их наяд төгрөгөөс хэтрүүлдэхгүй байх;
2. Монголбанкны Улсын байцаагчийн 2018 оны 2018/12039/005 дугаар мэдэгдэл дурдсан 4 зээлдэгчийн 9 эзэлд байгуулбал зохих 80.3 тэрбум төгрөгийн зээлийн эрсдэлийн санг нэмж байгуулах;
3. Банканд мөрдөгдөж буй заавар, журам, аргачлалыг Монголбанкны Ерөнхийлөгч, Сангийн сайдын хамтарсан 2017 оны А-294/340 дугаар тушаалаар батлагдсан "Нягтлан бодох бүртгэлийн багц материал", Монголбанкны Ерөнхийлөгчийн 2017 оны А-251 дүгээр тушаалаар батлагдсан "Хөгжлийн банкны активыг ангилах, активын эрсдэлийн сан байгуулах, зарцуулах журам"-д нийцүүлэн 2018 оны 12 дугаар сард багтаан шинэчлэн баталж, мөрдүүлэх;
4. "Хөгжлийн банкны активыг ангилах, активын эрсдэлийн сан байгуулах, зарцуулах журам"-ын дагуу активыг ангиж, эрсдэлийн санг бүрэн байгуулж хэвшүүлэх;
5. Монгол Улсын Хөгжлийн банкны тухай хуульд заасан удирдлагын эрх, үүргийг хэрэгжүүлж ажиллах, банкны зохистой засаглалыг сайжруулах тодорхой арга хэмжээг авч ажиллах;

6. Зээл олгоход хийгдэх судалгаа, шинжилгээг чанартай хийх, зээлийн үйл ажиллагаанд тавих дотоод хяналтыг сайжруулах, барьцаа хөрөнгийн үнэлгээг эрх бүхий мэргэжлийн үнэлгээнээр хийлгэх;

7. Эдийн засгийн нэг салбарт олгох зээл, зээлтэй адилтган тооцох активын нийлбэр, нийт зээл, зээлтэй адилтган тооцох активын харьцааг 2018 оны 12 дугаар сард багтаан тогтоон мөрдүүлэх;

8. Шалгалтын танилцуулгад тусгагдсан зөвлөмж, зааварчилгааг хэрэгжүүлэх, шалгалтаар илэрсэн зөрчлүүдийг давтан гаргахгүй байх;

9. Тайлан, мэдээг үнэн зөв гаргаж, тушаалаар өгсөн үүргийн биелэлтийг улирал тутамд Монголбанкны Хяналт шалгалтын газарт тайлагнаж байх.

ГУРАВ. Монгол Улсын Хөгжлийн банкнд жилд 2 удаа газар дээрх иж бүрэн шалгалт хийж байхыг Хяналт шалгалтын газар (Н.Батсайхан)-т даалгасугай.

МОНГОЛБАНКНЫ  
ЕРӨНХИЙЛӨГЧ



Н.БАЯРТСАЙХАН

UIN.MN  
СУДАЛГААНЫ САН



# Монголбанкнаас МУХБ-д 2021 онд хийсэн хэсэгчилсэн шалгалтын тухай

Нийгэм, эдийн засгийн нөхцөл байдал /2021 оны 7-р сарын байдлаар/

Үзүүлэлтүүд	7/31/2021
Инфляци	7.4 хувь /жилийн/
ДНБ /оны үнээр, их наяд төгрөгөөр/	19.7
Гадаад валютын албан нөөц /тэрбум ам.доллар/	4,576.7
Ам.долларын төгрөгтэй харьцуулсан албан ханш /төгрөгөөр/	2,849.1
Монголбанкны бодлогын хүү	6.0%
Банкны системийн нийт актив /их наяд төгрөг/	39.7
Улсын төсөв	
Орлого /их наяд төгрөг/	8.2
Зарлага /их наяд төгрөг/	9.8
Тэнцэл /их наяд төгрөг/	-1.6
Төлбөрийн тэнцэл /сая ам.доллар/	-245.9

ᠮᠣᠩᠭᠣᠯᠪᠠᠨᠭᠠᠨᠠᠭᠤᠨ

UHL.MN  
СУДАЛГААНЫ САН



# Монголбанкнаас МУХБ-д 2021 онд хийсэн ХЭСЭГЧИЛСЭН ШАЛГАЛТЫН ТУХАЙ

## МУХБ-НЫ 2021.07.31-НИЙ БАЙДЛААРХ ТЭНЦЭЛ

Монголбанкнаас 2021 онд хийсэн хэсэгчилсэн шалгалт

ХЭСЭГЧИЛСЭН ШАЛГАЛТ

Шалгах өдрөөр /2021.07.31/				
ХӨРӨНГӨ /тэрбум төгрөг/	Банкны тэнцэл	Тохируулга	Тохируулгын дараах	Эзлэх хувь
Мөнгөн хөрөнгө	724.3		724.3	21.8%
Хөрөнгө оруулалт	217.8		217.8	6.6%
Зээл (цэвэр)	2,270.7		1,515.0	45.6%
/ЗТУБАХСАН/	-581.8	-755.7	-1,337.5	
Нийт Зээл	2,852.5		2,852.5	
Бусад хөрөнгө	627.5		627.5	18.9%
Арилжаа (Дериватив санхүүгийн хөрөнгө)	210.8		210.8	6.3%
Үндсэн хөрөнгө (цэвэр)	25.3		25.3	0.8%
<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>4,076.4</b>		<b>3,320.7</b>	<b>100.0%</b>
ӨР ТӨЛБӨР /тэрбум төгрөг/				
Харилцах	14.0		14.0	0.5%
Хадгаламж	0.0		0.0	0.0%
Банк, СБ-с татсан эхүүсвэр	704.2		704.2	23.0%
Бусад эхүүсвэр	2,323.2		2,323.2	75.9%
Бусад өр төлбөр	9.5		9.5	0.3%
Арилжаа (Дериватив санхүүгийн өглөг)	10.4		10.4	0.3%
<b>ӨР ТӨЛБӨРИЙН НИЙТ ДҮН</b>	<b>3,061.4</b>		<b>3,061.4</b>	<b>92.2%</b>
<b>ЭЗЭМШИГЧДИЙН ӨМЧ</b>	<b>1,015.1</b>		<b>259.4</b>	<b>7.8%</b>
Тухайн жилийн ашиг, алдагдал	13.8	-755.7	-742.0	
Өмнөх үеийн ашиг алдагдал	-236.7		-236.7	
<b>ӨР ТӨЛБӨР БА ЭЗЭМШИГЧДИЙН ӨМЧ</b>	<b>4,076.4</b>		<b>3,320.7</b>	<b>100.0%</b>



# Монголбанкнаас МУХБ-д 2021 онд хийсэн шалгалтын тухай

Монголбанкнаас тогтоосон зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг хангасан байдал

Д/д	Зохистой харьцааны үзүүлэлт	2021.07.31-ний байдлаар		
		Банкнаас ирүүлсэн	Хянан шалгагчийн тооцсоноор	Зохистой харьцааг хангасан эсэх
1	Өөрийн хөрөнгө, эрсдэлээр жигнэсэн активын харьцаа ( $\geq 9.0\%$ )	34.00%	1.9%	Үгүй
2	Төлбөр түргэн гүйцэтгэх чадварын харьцаа ( $\geq 100\%$ )	161.0%	161.0%	Тийм
4	Зээл, баталгаа, зээлтэй адилтгах актив хөрөнгийн нийт дүн нь өөрийн хөрөнгийн хэмжээг 30 дахин нэмэгдүүлсэн хэмжээнээс хэтрэхгүй байх	3.8 дахин их	14.9 дахин их	Тийм
6	Нийт том зээлдэгчид олгосон зээл, зээлтэй адилтган тооцох хөрөнгө, баталгаа, батлан даалтын нийлбэр дүн нь нийт зээл, зээлтэй адилтгах актив, баталгаа, батлан даалтын нийлбэр дүнгийн 80%-иас хэтрэхгүй байх	74.7%	79.5%	Тийм

УИХ-аас

УИХ.МН  
СЭДАЛГААНЫ САН

Монголбанкнаас 2021 онд хийсэн хэсэгчилсэн шалгалт



# Монголбанкнаас МУХБ-д 2021 онд хийсэн ХЭСЭГЧИЛСЭН ШАЛГАЛТЫН ТУХАЙ

## □ Монголбанкнаас шалгалтаар илэрсэн зөрчилд тогтоосон акт, мэдэгдэл

1. Мөн зээлийн эрсдэлийн санг 755.7 тэрбум төгрөгөөр нэмж байгуулах тохируулгын гүйлгээг хийсэн нөхцөлд тус банкны өөрийн хөрөнгө, эрсдэлээр жигнэсэн активын харьцаа 1.9 хувь болж, Монголбанкны Ерөнхийлөгчийн 2020 оны А-464 дүгээр тушаалаар баталсан “Хөгжлийн банкны үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлт болон үйл ажиллагааны хязгаарлалтыг тогтоох, түүнд хяналт тавих журам”-ын 2.2 дахь заалтад заасан өөрийн хөрөнгийн хүрэлцээний зохистой харьцааг 7.1 нэгж хувиар хангахгүй байв.
2. Монголбанкны Ерөнхийлөгч, Сангийн сайдын хамтарсан 2017 оны А-294/340 дугаартай тушаалаар батлагдсан “Нягтлан бодох бүртгэлийн багц материал”-ын 4.3-ийн Г хэсгийн 6 дахь заалт болон “Хөгжлийн банкны активыг ангилах, активийн эрсдэлийн сан байгуулах, зарцуулах журам”-д заасны дагуу тооцож, шалгах өдрөөр буюу 2021 оны 7 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар 1.7 их наяд төгрөгийн зээлийн өрийн үлдэгдэл бүхий 40 зээлдэгчийн зээлд нийт 755.7 тэрбум төгрөгийн зээлийн эрсдэлийн санг нэмж байгуулах тухай Улсын байцаагчийн 2021/12039/01 дугаартай мэдэгдэл хүргүүлсэн.

Хөгжлийн банкны үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлт болон үйл ажиллагааны хязгаарлалтыг тогтоох, түүнд хяналт тавих журам

МОНГОЛ БАНКНЫ  
СҮДАЛ ААНЫ САН



# Монголбанкнаас МУХБ-д 2021 онд хийсэн хэсэгчилсэн шалгалтын тухай

Монголбанкнаас 2021 онд хийсэн хэсэгчилсэн шалгалт

## □ Монголбанкны Ерөнхийлөгчийн тушаалаар өгсөн үүрэг, даалгавар



2021 оны 12 сарын 15 өдөр Дугаар А-336 Улаанбаатар хот

Монгол Улсын Хөгжлийн банканд хийсэн шалгалтын дүнгийн тухай

Монгол Улсын Хөгжлийн банканд хийсэн хэсэгчилсэн шалгалтаар банкны тайлан тэнцэлд тохируулга хийсэн нөхцөлд Монголбанкнаас тогтоосон өөрийн хөрөнгийн хүрэлцээний зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг банк хангахгүй байгаа, зээлийн эрсдэлийн санг бүрэн байгуулаагүйг тэмдэглэн, Төв банк (Монголбанк)-ны тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг, 27 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 2 дахь заалт, 28 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 2 дахь заалт, Монгол Улсын Хөгжлийн банкны тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.9 дэх заалт, 21 дүгээр зүйлийн 21.6.2 дахь заалт, 25 дугаар зүйлийн 25.2 дахь заалт, Банкны тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.2.1, 43.2.5, 43.2.6 дахь заалт, 48 дугаар зүйлийн 48.1.1, 48.1.5, 48.1.16 дахь заалт, Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, мөнгөн хөрөнгийн шилжүүлэг, зээлийн үйл ажиллагааны тухай хуулийн 27 зүйлийн 27.1 дэх хэсэг, "Хөгжлийн банкны активыг ангилах, активын эрсдэлийн сан байгуулах, зарцуулах журам"-ын 1.3, 1.6 дахь заалт, "Хөгжлийн банкны үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлт болон үйл ажиллагааны хязгаарлалтыг тогтоох, түүнд хяналт тавих журам"-ын 1.2, 2.2, 7.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

НЭГ. Шалгалтын акт, материалыг нэгдүгээр хавсралтаар, зөрчлийн жагсаалтыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

ХОЁР. Монгол Улсын Хөгжлийн банкны Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дарга (С.Наранцогт), Гүйцэтгэх захирлын үүрэг гүйцэтгэгч (Н.Мандуул) нарт үүрэг болгох нь:

1. Монголбанкны Ерөнхийлөгчийн 2019 оны 07 дугаар сарын 03-ны өдрийн А-184 дүгээр тушаалын 1 дэх заалтыг хэвээр мөрдөх;
2. Монголбанкны Улсын байцаагчийн 2021 оны 2021/12039/01 дугаартай мэдэгдэлд дурдсан зээлдэгчдийн зээлд байгуулах эрсдэлийн санг нэмж байгуулах;
3. Монголбанкны Ерөнхийлөгчийн 2020 оны А-470 дугаар тушаалаар батлагдсан "Хөгжлийн банкны активыг ангилах, активын эрсдэлийн сан байгуулах, зарцуулах журам"-ыг үйл ажиллагаандаа мөрдөж ажиллах, зээлийн ангиллыг уг журмын дагуу тогтоож, зээлийн мэдээллийн санд хүргүүлж хэвших;
4. Монгол Улсын Хөгжлийн банкны тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1 дэх хэсэгт заасан Хөгжлийн банкнаас санхүүжүүлэх төсөл хөтөлбөрт тавигдах шаардлагыг хангасан эсэхийг үнэлэх, дүгнэлт өгөх тодорхой шалгуур, аргачлал, зааврыг шинэчилж, мөрдөх;
5. Монгол Улсын Хөгжлийн банкны тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.2 дахь хэсэгт заасан шаардлага хангасан төсөл хөтөлбөрийг санхүүжүүлэхдээ гадаад, дотоодын банк, санхүүгийн байгууллага, хөрөнгө оруулагчидтай хамтран санхүүжүүлэх заалтыг хангасан эсэхийг үнэлэх, дүгнэлт өгөх тодорхой шалгуур, аргачлал, зааврыг шинэчилж, мөрдөх;
6. Зээлийн эрсдэлийн удирдлага, дотоод хяналтын тогтолцоог сайжруулах, зээл чанаргүйдэхээ сэргийлэх арга хэмжээг урьдчилан авч байх, зээлийн бодлого, холбогдох журмуудыг үйл ажиллагаандаа бүх шатанд мөрдөж ажиллах;

7. Чанаргүй активыг төлүүлэх талаар шүүх, хууль, хяналтын байгууллагад тухай бүр хандаж ажиллах, банкнаас авч хэрэгжүүлж буй арга хэмжээг эрчимжүүлэх, барьцаа хөрөнгөгүй зээлүүдийг барьцаажуулах, барьцаа хөрөнгө хангалтгүй зээлүүдэд нэмж хөрөнгө барьцаалах;

8. Гадаад валютын эх үүсвэрээр гадаад валютаар орлого олдог зээлдэгчийн хэрэгжүүлэх төсөл хөтөлбөрийг санхүүжүүлдэг байх талаар зээлийн бодлого, журамд тусган, мөрдөж ажиллах;

9. Нэг зээлдэгч, түүнд холбогдох этгээдийг Банкны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.2 дахь заалтын дагуу тогтоож, зээлийн үйл ажиллагааны хязгаарлалтын тайлан мэдээнд тайлагнаж хэвших;

10. Арилжааны банкны нөлөө бүхий хувьцаа эзэмшигч, түүний холбогдох болон харилцан хамаарал бүхий этгээдэд олгох зээлийг хязгаарлах, банкны хөрөнгө, орлогыг барьцаанд барьцаалахгүй байх, банкны хувьцаа эзэмшигчээр гаргуулах баталгаа, батлан даалтыг хязгаарлах талаар дотоод журам зааварт тусган, хэрэгжүүлэх;

11. Эрсдэлийн удирдлагын бодлого, арга барил, болон хяналтын үйл ажиллагааг банкны эрхлэх үйл ажиллагааны цар хүрээ, эрсдэлийн төлөвтэй уялдуулан сайжруулах;

12. Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүдийн тогтвортой байдлыг хангаж, түүний дэргэдэх хороодын хяналт, Дотоод аудитын газрын үйл ажиллагааг эрчимжүүлэх, зээл олгох тухай Төлөөлөн Удирдах Зөвлөлийн тогтоол, шийдвэр гарсны дараах дотоод хяналт, үнэлгээнд тавих хяналтыг сайжруулах;

13. Шалгалтын танилцуулгад тусгагдсан зөвлөмж, зааварчилгааг хэрэгжүүлэх, шалгалтаар илэрсэн зөрчлүүдийг давтан гаргахгүй байх;

14. Энэ тушаалаар өгсөн үүргийн биелэлтийг улирал бүр Монголбанкны Хяналт шалгалтын газарт тайлагнаж байх;

ГУРАВ. Энэхүү тушаал гарсантай холбогдуулан Монголбанкны Ерөнхийлөгчийн 2018 оны 11 дүгээр сарын 27-ны өдрийн А-290 дүгээр тушаалын 2, 3, 4, 5, 6, 7, 8, 9 дэх заалтыг хүчингүй болсонд тооцсугай.

ДӨРӨВ. Энэ тушаалын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт шалгалтын газар (Ц.Нарандалай)-г даалгасугай.



ЕРӨНХИЙЛӨГЧ

БЛХАГВАСҮРЭН

Handwritten signature in blue ink





# Цаашид авах арга хэмжээ

1. Банкны засаглалтай холбоотой зөвлөмжийн хүрээнд:
  - 1) МУХБ-ны зорилго зорилт, стратегид нийцсэн, үүрэг хариуцлага, хүлээх эрсдэлийн талаар тодорхой тусгасан “Банкны зохистой засаглалын бодлого” боловсруулан баталж, хяналт тавин ажиллах;
  - 2) Банкны үйл ажиллагаатай холбоотой аливаа асуудлыг мэргэжлийн түвшинд сонирхлын зөрчилгүй, хараат бус байдлаар шийдвэрлэх чадвартай ТУЗ-ийн гишүүдийг томилох;
  - 3) Хувьцаа эзэмшигчид нь ТУЗ-ийн гишүүдтэй гэрээ байгуулах, ТУЗ-өөс гүйцэтгэх удирдлагын ажлын гүйцэтгэл, гэрээний үр дүнг үнэлж, дүгнэлт өгөх, гүйцэтгэх удирдлагуудын ажлын байрны тодорхойлолтыг шинэчлэн баталж, эрх мэдэл, хяналтын заагийг оновчтой тогтооход анхаарч ажиллах;

ᠴᠠᠠᠰᠢᠳᠠᠭᠠᠬᠤ ᠠᠷᠭ᠎ᠠ ᠬᠡᠮᠵᠡᠭᠡ


UIN.MN  
СУДАЛГААНЫ САН



## Цаашид авах арга хэмжээ

2. Зээлийн үйл ажиллагаатай холбоотой зөвлөмжийн хүрээнд:
  - 1) Монгол Улсын Хөгжлийн банкны тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1 дэх хэсэгт заасан Хөгжлийн банкнаас санхүүжүүлэх төсөл хөтөлбөрт тавигдах шаардлагыг хангасан эсэхийг үнэлэх, дүгнэлт өгөх тодорхой шалгуур, аргачлал, зааврыг шинэчилж, мөрдөх;
  - 2) Монгол Улсын Хөгжлийн банкны тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.2 дахь хэсэгт заасан шаардлага хангасан төсөл хөтөлбөрийг санхүүжүүлэхдээ гадаад, дотоодын банк, санхүүгийн байгууллага, хөрөнгө оруулагчидтай хамтран санхүүжүүлэх заалтыг хангасан эсэхийг үнэлэх, дүгнэлт өгөх тодорхой шалгуур, аргачлал, зааврыг шинэчилж, мөрдөх;
  - 3) Зээлийн эрсдэлийн удирдлага, дотоод хяналтын тогтолцоог сайжруулах, зээл чанаргүйдэхээс сэргийлэх арга хэмжээг урьдчилан авч байх, зээлийн бодлого, холбогдох журмуудыг үйл ажиллагаандаа бүх шатанд мөрдөж ажиллах;

ᠴᠠᠠᠰᠢᠳᠠᠶ᠋ᠠᠬᠤ ᠠᠷᠭ᠋᠎ᠠ ᠬᠡᠮᠵᠡᠭᠡ





## Цаашид авах арга хэмжээ

2. Зээлийн үйл ажиллагаатай холбоотой зөвлөмжийн хүрээнд:
  - 4) Чанаргүй активыг төлүүлэх талаар шүүх, хууль, хяналтын байгууллагад тухай бүр хандаж ажиллах, банкнаас авч хэрэгжүүлж буй арга хэмжээг эрчимжүүлэх, барьцаа хөрөнгөгүй зээлүүдийг барьцаажуулах, барьцаа хөрөнгө хангалтгүй зээлүүдэд нэмж хөрөнгө барьцаалах;
3. Ханшийн эрсдэлтэй холбоотой зөвлөмжийн хүрээнд:
  - 1) Гадаад валютын эх үүсвэрээр гадаад валютаар орлого олдог зээлдэгчийн хэрэгжүүлэх төсөл хөтөлбөрийг санхүүжүүлдэг байх талаар зээлийн бодлого, журамд тусган, мөрдөж ажиллах;
  - 2) МУХБ-ны тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.4, 8.1.6-т заасан үйл ажиллагааны дагуу валютын ханшийн эрсдэлийг оновчтой удирдах, хяналтын тогтолцоог бий болгох;
4. Активын пассивын хугацааны зөрүүний шинжилгээг тогтмол хийж, хяналт тавьж ажиллах, банкны хүлээн зөвшөөрөх эрсдэлийн хэм хэмжээний түвшинд урт хугацааны төлбөрийн чадварын үзүүлэлтийг активын пассивын хугацааны зөрүүний шинжилгээтэй уялдуулах;

ᠴᠠᠠᠰᠢᠳᠠᠭᠠᠬᠤ ᠠᠷᠭ᠎ᠠ ᠬᠡᠮᠵᠡᠭᠡ

UHMN  
ᠴᠠᠠᠰᠢᠳᠠᠭᠠᠬᠤ ᠠᠷᠭ᠎ᠠ